



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А/137

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.5, 11.1.7, 45 дугаар зүйлийн 45.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 7.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.1 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн салбарын удирдах ажилтныг чадавхжуулах сургалтанд шаардагдах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 4,675,000 (дөрвөн сая зургаан зуун далан таван мянган) төгрөгийг "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж Эрүүл мэндийн газар О.Баатарчулуун-д шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Эрүүл мэндийн газар (О.Баатарчулуун)-т үүрэг болгосугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ